



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2009 оны 6 сарын 25 өдөр

Дугаар 153

Улаанбаатар хот

**Даатгалын компанийн дүрмийн сангийн
доод хэмжээг тогтоох тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1.Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 1 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 2 тэрбум төгрөг, давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 5 тэрбум төгрөгөөр тус тус тогтоосугай.

2.Энэ тогтоолын 1 дүгээр заалтаар тогтоосон даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг бүрдүүлсэн тухай холбогдох материалаа 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор бүрдүүлж Хороонд ирүүлэхийг даатгалын компаниудад үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын 2-т заасан хугацаанаас өмнө ердийн, урт хугацааны болон давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч Хороонд хандсан хуулийн этгээд дүрмийн сангаа энэ тогтоолын 1-д заасан хэмжээгээр бүрдүүлсүгэй.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор нэмсэн/

4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН